

УСАН ЗАМЫН ЗОГСООЛ БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙГ АШИГЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү журмын хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага болон эрх олгогдсон (ахлах) хяналтын улсын байцаагчид хяналт тавина.

- 1.1. Зогсоолын усан бүс гэж усан замын тээврийн хэрэгсэл зогсоолд аюулгүй ойртох, гарах хөдөлгөөнийг чөлөөтэй хийх зориулалттай байгалийн болон хиймэл усан сан доторх хил хязгаарыг;
- 1.2. Зогсоолын нутаг дэвсгэр гэж зогсоолын зэргэлдээх эрэг дээрх талбай бүхий газар, үүнд зорчигчийн үйлчилгээ, усан замын тээврийн хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх, хадгалах зориулалттай байр, өргөгч цамхаг, бусад шаардлагатай байгууламжийг зогсоолын хүчин чадлаас шалтгаалан төлөвлөж болно.
- 1.3. Хөвдөг зогсоолын тавцангийн эргийн бэхэлгээ нь усны түвшнээс дээш 10-15см, бэхлэгдсэн бэхэлгээний цэгүүдийн хоорондох 1.5 м-ээс ихгүй зайтай байна. Хөвөгч бэхэлгээний байгууламжууд (понтон, бэхэлгээний торх) нь эрэг дээр бэхлэгдсэн байх, эсвэл байнгын зангуу ашиглан хөдөлгөөн байрлуулж болно.

ХОЁР. ЗОГСООЛ БАЙГУУЛАХ, ТӨЛӨВЛӨХ

- 2.1. Усан онгоцны зогсоол нь үйлчилгээний байр, автомашины зогсоол, галын машины ус авах газар, эрэг дээрх байгууламж руу нэвтрэх зам, усны байгууламжийн зогсоолын суурь, гарцыг барилгын зураг төслийг боловсруулахдаа тусгаж болох бөгөөд дараахь шаардлагыг үндлэл болгоно.
 - 2.1.1. Ундны усны эх үүсвэрийн ариун цэврийн хамгаалалтын бүсийн нэг ба хоёрдугаар бүсээс гадна, урсгал, давлагаа, салхины нөлөө багатай, цөн түрэлтээс хамгаалагдсан байгалын болон хиймэл усан сангийн эрэгт байрладаг.
 - 2.1.2. Зогсоолын усан бүсэд зогсоол руу орох гарцууд нь усан замын тээврийн хэрэгслийн зориулалт тохирсон, түүнийг саадгүй нэвтрүүлэхэд хангалттай өргөн, гүнтэй байна.
 - 2.1.3. Хүн олноор цугласан усанд сэлэх зориулалтаар тохижуулсан наран шарлагын газраас 100 метрээс бага зайд аврах зориулалттай завь бусад зориулалтын усан замын тээврийн хэрэгслийн зогсоолоос бусад зориулалтын тээврийн хэрэгслийн зогсоол болон хөвөгч байгууламжийг ажиллуулахыг хориглоно.
 - 2.1.4. Зогсоол нь эрэг дээр найдвартай бэхлэгдсэн гүүр эсвэл шатаар холбогдсон байх, орох хаалга нь хашлагатай байх ёстой.

2.1.5. Эрэг болон зогсоол хоорондоо харилцах зориулалттай шат, гарц, гүүр, нэг чиглэлийн хөдөлгөөнд 0.8-1 метрээс багагүй, хоёр талын хөдөлгөөнд 1.5 метрээс багагүй өргөнтэй, хатуу шал, хашлагатай, хашлагын 90 см-ээс багагүй өндөртэй, шонгийн хоорондох зай 1.5 метрээс ихгүй байна.

2.1.6. Иж бүрдэл гал унтраах хэрэгсэл, элс, хүрз бүхий хайрцаг, эсгий дэвсгэр, аврах хөвүүр 50 метрийн зайд, нэг зогсоол, эсвэл зогсоол бүрт хамгийн багадаа нэг багц байна.

2.1.7. Усан замын тээврийн хэрэгсэл ойртох, байруулах, бэхлэх, гарах, зорчигчийг суулгах, буулгах, ачаа ачих, буулгах, хадгалах зориулалттай байгалийн болон, хиймэл усан бүсийг төлөвлөх бөгөөд усан бүс дотор усан замын тээврийн хэрэгсэл чөлөөтэй маневр хийх аюулгүй байдлыг хамгийн их хэмжээтэй байна.

2.1.8. Зогсоол байгуулах газрын байршил нь усны ундрага, голын голидролыг өөрчлөх, урсгалыг бөглөх, шавхагдахаас хамгаалах, усны амьтан, ургамлын биологийн нөөц, эко сиситемийг алдагдуулахааргүй байх ёстой.

2.1.9. Усанд сэлэх зориулалттай усан сангийн бүсэд 0,5 метр/секундээс дээш хурдтай гүний усны гаралт, усны эргүүлэг, юүлүүр, урсгал байх ёсгүй.

2.1.10. Усан замын зогсоолыг барьж байгуулж, төлөвлөхдөө орон нутгийн нөхцөл байдлыг харгалзах бөгөөд усан цахилгаан станц, бохир ус зайлуулах цэг, уул уурхайн усан сан, загас үржүүлэг (тухайн ажил үүргийн зориулалтаас бусад), усалгааны газар, түүнчлэн бусад бохирдлын эх үүсвэртэй усан бүхий газарт байгуулахыг хориглоно.

ГУРАВ. ТАВААС ДЭЭШ УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЗОГСООХ ХҮЧИН ЧАДАЛТАЙ УСАН ЗАМЫН ЗОГСООЛД ТАВИГДАХ ЭНГИЙН ШААРДЛАГА

- 3.1. Зогсоолын эрэг дээрх зэргэлдээх талбайд цаг агаарын талаар мэдээлэх чанга яригч төхөөрөмж, радио болон харилцаа холбооны хэрэгслээр тоноглогдсон байх;
- 3.2. мэдээллийн самбар, усны ослоос урьдчилан сэргийлэх аврах хэрэгслүүд, сандал, сүүдрэвч, хогийн сав зэргийг мөн хангасан байх;
- 3.3. Хатуу хог хаягдлыг дахин боловсруулах орон нутгийн холбогдох байгууллагатай хог хаягдлыг зайлуулах гэрээтэй байх ёстой.

ДӨРӨВ. ХОРИОС ДЭЭШ УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЗОГСООХ ХҮЧИН ЧАДАЛТАЙ УСАН ЗОГСООЛД ТАВИГДАХ ЭНГИЙН ШААРДЛАГА

- 4.1. Тасалбар худалдаалах цэг байршуулсан байх;
- 4.2. Зогсоолын оператор, диспетчер ажиллуулах;

- 4.3. Зогсоол орж ирсэн, байрлуулсан усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, жолоочийн мэдээлэл, тээврийн хэрэгслийн төрөл, нэр, улсын дугаарыг усан замын төв буудлын зогсоолын бүртгэлд оператор, диспитчер бүртгэл хийдэг байх;
- 4.4. Усан замын тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцох, зогсоол руу буцаж ирэх бүрт огноо, хугацаа, зогсоол руу буцах цагийг тооцож бүртгэлд дараалсан байдлаар бичилт хийдэг байх;
- 4.5. Хүрээлэн буй орчныг хамгаалах, галын аюулгүй байдлын зохих шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд усан замын тээврийн хэрэгслийг түлш, шатахуунаар цэнэглэх газартай байж болно;
- 4.6. Усны бүсэд газрын тосны бүтээгдэхүүний асгаралтыг яаралтай зогсоох хэрэгсэл (бон, сорбент или скиммер, сорбционная емкость) байнгын бэлэн байдалд зайлшгүй байлгах;
- 4.7. Зогсоол болон усан замын тээврийн хэрэгсэлтэй холбогдох радио холбооны станцуудыг суурилуулсан байх;
- 4.8. Зогсоол руу усан замын тээврийн хэрэгсэл орох, гарах урсгалын чиглэлийг заасан усан замын тэмдэг, тэмдэглээг зайшлгүй байршуулсан байх
- 4.9. Зогсоолын нутаг дэвсгэр дээр дараахь зүйлсээр тоноглогдсон байна. Үүнд:
 - Ахуйн хог хаягдлын сав, хаягдал шатах тослох материал цуглуулах сав бүхий талбай;
 - Усны ослоос урьдчилан сэргийлэх талаар иргэдэд зориулсан зааварчилгаа бүхий мэдээллийн самбар (агуулгад: хууль тогтоомж, эрх зүйн актуудын ишлэл, завины үйлчилгээний мэдээлэл, усанд осолдсон хүмүүст тусламж үзүүлэх арга замууд, усан бүсэд осолдсон завь, усан онгоцонд үзүүлэх аврах ажиллагаа, галын аюулын үед авах арга хэмжээний схем, гал түймэр унтраах, аврах ангийн болон эмнэлгийн яаралтай түргэн тусламж үзүүлэх байгууллагын утасны дугаар)
 - Зогсоолын нутаг дэвсгэрт гал унтраах автомашин нэвтрэх гарц;
 - Ус цаг уурын болон навигацийн нөхцөл байдлын талаар усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч, өмчлөгч, жолооч, зорчигчдод мэдээлэх радио холбооны хэрэгслээр тоноглогдсон байх;
 - Усны гүнийг хэмжсэн, шумбалтын үзлэг;
Цаг агаарын урьдчилсан мэдээ, усны түвшин, аяллын мэдээллийн гарын авлага;
 - Ус ашиглах тухай орон нутгийн эрх бүхий байгууллагатай хийсэн гэрээ, шийдвэр.
 - Дотоод дүрэм, журам, ажиллах цагийн хуваарь, төлөвлөгөө, мэдээллийг жолооч, зорчигчид уншиж, танилцах боломжтой байдлаар байрлуулсан байх;

ТАВ. УСАН ЗАМЫН ЗОГСООЛ /ТӨВ БУУДАЛ/ ӨМЧЛӨГЧ, ЭЗЭМШИГЧИЙН ҮҮРЭГ

- 5.1. Зогсоолын өмчлөгч, эзэмшигч, удирдлага нь зогсоолыг ашиглах, дүрэм, журмыг батлах, мөрдүүлэх, усан замын тээврийн хэрэгслийн жолооч, зогсоолын ажилтны аюулгүй байдлыг хангуулах үүрэгтэй.
- 5.2. Усан замын зогсоолын усан бүс, зэргэлдээх нутаг дэвсгэрт зорчигч, үйлчлүүлэгч болон усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, жолоочийг хөвөлтийн аюулгүй

байдлыг хангах болон байгаль орчныг хамгаалах тухай хууль, тогтоомжийн талаар заавар зөвлөмжөөр хангах үүрэгтэй. Зогсоол тус бүр дээр цаг агаарын урьдчилсан мэдээг хүлээн авч, аялалд оролцож буй навигацуудад мэдээлэх ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

- 5.3. Хөвөлтийн улирал эхлэхээс өмнө (хаврын шар усны үерийн дараа) зогсоолын усан бүсэд гүний хэмжилт, мөн ёроолын шумбалтын судалгааг зохих зөвшөөрөлтэй байгууллагаар хийж гүйцэтгүүлж болно. Хөвөлтийн улирал эхлэхээс өмнө усны талбайн ёроолыг шумбагчид шалгаж, хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй усны ургамал, хагархай, чулуу, шил, бусад зүйлээс цэвэрлэнэ. Объектууд, эргийн шугамаас (усны ирмэг) дор хаяж 15 метрийн зайд 1.75 метрийн гүнд ирмэггүй аажмаар налуутай байна.
- 5.4. Ус, усан орчин ашиглагч нь усны нөөцийг хамгаалах, бохирдох, бөглөрөх, шавхагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй.
- 5.5. Усны барилга байгууламж, түүний хэсгийг амралт зугаалгын зориулалтаар ашиглаж байгаа ус ашиглагч эдгээр зориулалтаар олгосон усан сан, тэдгээрийн хэсэгт байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг хариуцна.
- 5.6. Жил бүр хөвөлтийн улирал эхлэхээс өмнө зогсоолын өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь зогсоолын тулгуур, шат, гарц, явган хүний гүүрэн гарц хэвийн ажиллагааны бэлтгэлийг шалгаж, бэлэн байдалд оруулах үүрэгтэй.
- 5.7. Гал түймэр, онцгой байдлын аврах анги, эмнэлгийн байгууллагууд, хууль хяналтын байгууллагуудын нэгжүүдтэй байнгын харилцаатай байх үүрэгтэй.

ЗУРГАА. ЗОГСООЛЫГ АШИГЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА

- 6.1. Түрээсээр ашиглаж болох бөгөөд түрээсээр ашиглах бол Иргэний тухай хуулийн дагуу гэрээ байгуулах;
- 6.2. Усанд дал болон уснаас ил гарсан зогсоолын бэхэлгээ болон бусад байгууламж дээр 100 метрийн зайнаас харагдахуйц шинийн цагт цагаан өнгийн гэрлээр тэмдэглэгээ хийх;
- 6.3. Шөнийн цагаар зогсоолын нутаг дэвсгэр, усны талбайг гэрэлтүүлэх ёстой бөгөөд гэрлийн тусгал нь зогсоолд ойртох болон хажуугаар өнгөрч буй усан замын тээврийн хэрэгслийн жолоочийн үзэгдэх орчныг хязгаарлахааргүй байх;
- 6.4. Усны түвшин нэмэгдсэн /үерт автсан/ зогсоолын бэхэлгээ, хамгаалалтын хэрэгсэл, түүнчлэн усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдалд шууд заналхийлж болзошгүй саад тотгорыг усан замын тэмдэг, тэмдэглэгээг байршуулсан байх;
- 6.5. Усан замын тээврийн хэрэгсэл, зогсоолын тавцан, хаалт хашлагнаас ус руу үсрэх, зогсоолын усан бүст усанд сэлэхийг хатуу хориглох;

- 6.6. Усны бүс, талбайн хил хязгаарыг тогтоосон усан замын тэмдэг, тэмлэгээнд хөвөгч ахуйн хог хаягдал /канистр, ундааны сав/ зэрэг зориулалтын бус хөвөөр, тод биш ялгарахгүй өнгийн харагдахгүй зүйлсийг ашиглахыг хориглох;
- 6.7. Зогсоол бүрт шаардлагатай бол тогтоосон журмаар зөрчлөөр саатуулсан усан тээврийн хэрэгслийг хадгалах газрыг бий болгож болох бөгөөд усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч, зээмшигч, жолоочийн зардлаар хадгалах, зөрчил барагдуусны дараагаар тухайн тээврийн хэрэгслийн өмчлөгч, зээмшигч, жолооч шилжүүлэх;
- 6.8. Хөдөлгүүрийн засварыг зогсоолын нутаг дэвсгэрт тусгайлан заасан зориулалтын засварын газарт хийж, усанд болон хөрсөнд тос, бензин, бохир ус, тостой даавуу орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- 6.9. Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах, агуулах байгууламжийг дотор эсвэл саравчтай тусгай талбайд байрлуулах;
- 6.10. Хүчтэй салхи шуурга, усны халиа, үерээс усны түвшин нэмэгдсэн тохиолдолд газрын тосны бүтээгдэхүүнийг усан сан руу орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай.

ДОЛОО. ЗОГСООЛЫН АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

- 7.1. Зогсоолын аюулгүй байдал, тэдгээрийн хэвийн ажиллагааг тодорхойлохын тулд анхан шатны, ээлжит болон ээлжит бус хяналтын үзлэг, шалгалтыг явуулж болно.
- 7.2. Зогсоолыг ашиглалтад хүлээн авахын өмнө анхан шатны үзлэг, шалгалтыг хийнэ.
- 7.3. Усан замын аюулгүй байдалтай холбоотой гэрчилгээ олгох зорилгоор ээлжит үзлэг хийнэ.
- 7.4. Зогсоолын үндсэн шинж чанарыг өөрчилсөн томоохон засвар, шинэчлэл, дахин тоног төхөөрөмж, байгалийн гамшиг болон иргэний гомдлын дагуу ээжит бус үзлэгийг хийж болно.